

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ**

2025 оны 09 дүгээр
сарын 28-ний өдөр

Дорноговь аймаг

**Орон нутгийн 2025 оны төсвийн орлогын бүрдүүлэлтийн
талаар авах зарим арга хэмжээний тухай**

Тус хэлтсийн 2025 оны 9 дүгээр сарын мэдээний дүнгээр орон нутгийн төсөвт 535,945,803 төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Орон нутгийн төсөвт төвлөрүүлж буй орлогын 0,8 хувийг тэмдэгтийн хураамжийн орлого, 99 хувийг үл хөдлөх эд хөрөнгийн 2 хувь борлуулсны орлого, 0,2 хувийг Зөрчлийн тухай хуулийн дагуу хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдэж буй торгуулийн орлого тус тус бүрдүүлсэн байна.

Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:

Тайлант хугацаанд буюу 2025 оны 9 сарын мэдээгээр үндэсний энгийн гадаад паспорт 372, иргэний цахим үнэмлэх, шилжилт хөдөлгөөний бүртгэл 391 бүртгэлийг хийж 3,346,600 төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлогыг төвлөрүүлсэн

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:

Тайлант хугацаанд буюу 2025 оны 9 сарын мэдээгээр шинээр байгуулсан хуулийн этгээдийн бүртгэл-17, Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн бүртгэл-27, Хуулийн этгээдийн салбар төлөөлөгчийн газар шинээр бүртгүүлсэн-1 бүртгэл хийж 1,038,000 төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлогыг төвлөрүүлсэн.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:

Тайлант хугацаанд буюу 2025 оны 9 сарын эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхээ бүртгүүлэхээр үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл 83, худалдах, худалдан авах гэрээгээр өмчлөх эрх шилжсэн бүртгэлийн 242 мэдүүлгийг хүлээн авч хугацаанд нь хянан шийдвэрлэсэн. Эдгээр үйлчилгээг хийснээр 199,592 төгрөгийн тэмдэгтийн хураамж, үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулсны 2 хувь болох татвар 530,441,203 төгрөгийг орон нутгийн дансанд тус тус төвлөрүүлсэн.

Зөрчил шалган шийдвэрлэх чиглэлээр:

Тайлант хугацаанд буюу 2025 оны 9 сарын байдлаар Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 53 иргэнд зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж 1,120,000 төгрөгийн торгох шийтгэл оногдуулсан байна.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС